

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2023/31/-НА-СТА-ТШЗ

ТӨВ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН ДЭРГЭДЭХ САНХҮҮГИЙН ХЯНАЛТ,
ДОТООД АУДИТЫН АЛБАНЫ 2022 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН,
ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

Зуунмод 2023 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитор Г.Баянжаргал

Утас: 70273204 Цахим хаяг: bayanjargalg@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.open.audit.mn

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	4
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	7
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	12
4. АУДИТЫН ТАЙЛАН.....	16
4.1 Ерөнхий зүйл.....	16
4.2 Материаллаг байдал	16
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	16
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал..	16
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	17
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	17
4.5.1 Завсрын аудитын талаар.....	17
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал.....	17
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	18
5.1 Төлбөрийн акт.....	18
5.2 Зөвлөмж.....	18
6. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА,ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ.....	19
6.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл.....	19
6.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл	19
6.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал..	19

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ



ТӨВ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Улаанбаатар, Төв аймгийн Засаг даргын
Төв аймгийн Засаг даргын Тамгын газрын
Хүрээлэн, 10000-00000-00000

Хугацаа: 2023.02.15 № 01/49
Тангир: _____ Өмд №: _____ -Т

ТӨВ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ДЭРГЭДЭХ САНХҮҮГИЙН ХЯНАЛТ,
ДОТООД АУДИТЫН АЛБАНЫ
ДАРГА Б.САРУУЛ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Төв аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Төв аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторов баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторов ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Байгууллага үйл ажиллагаагаа тасралтгүй явуулахтай холбоотой тодорхой бус байдал үүсээгүй болно.

Аудитын гол асуудал

Санхүүгийн тайлангийн аудитад нөлөө үзүүлэх материаллаг буруу илэрхийлэл, нөлөө бүхий эрсдэл, удирдлагын үлэмж хэмжээний шийдэл орсон асуудал буюу нөлөө бүхий ажил гүйлгээ байхгүй байна.

Бусад асуудлын хэсэг

Аудитыг гүйцэтгэхэд аудитын хамрах хүрээний хязгаарлалт хийх шаардлагагүй болон хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй нөхцөл үүсээгүй тул бидний олж авсан нотолгоо нь аудитын дүгнэлтийн суурь болоход хүрэлцээтэй, зохистой гэж үзлээ. Тус санхүүгийн тайланд толилуулаагүй, тодруулаагүй асуудал байхгүй болно

G/Arkhiy/Alban bichig 2023/A4
19020042

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	3,705,650.1	2,978,982.1
35	БАРАА МАТЕРИАЛ	3,705,650.00	2,978,982.00
354	Хангамжийн материал	3,705,650.00	2,978,982.00
35410	Бичиг хэргийн материал	832,840.00	966,290.00
35420	Аж ахуйн материал	2,336,270.00	1,017,920.00
35430	Сэлбэг хэрэгсэл	260,000.00	260,000.00
35440	Түлш, шатах тослох материал	276,540.00	734,772.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	25,915,863.34	17,902,495.38
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	25,915,863.34	17,902,495.38
392	Биет хөрөнгө	25,915,863.34	17,902,495.38
39203	Авто-тээврийн хэрэгсэл	33,000,000.00	33,000,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-15,124,999.89	-20,624,999.85
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	12,869,450.00	12,869,450.00
39206	Хуримтлагдсан элэгдэл	-8,499,855.27	-10,226,535.27
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	8,305,405.00	8,305,405.00
39208	Хуримтлагдсан элэгдэл	-4,634,136.50	-5,420,824.50
39301	Програм хангамж	880,000.00	880,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-880,000.00	-880,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	29,621,513.34	20,881,477.38
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	29,621,513.34	20,881,477.38
51	Засгийн газрын хувь оролцоо	29,621,513.34	20,881,477.38
512	Хуримтлагдсан үр дүн	29,621,513.34	20,881,477.38
51210	Өмнөх үеийн үр дүн	29,621,513.34	29,621,513.34
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-8,740,035.96
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	29,621,513.34	20,881,477.38

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	163,678,300.00	187,599,800.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	00.00	27,000.00
120	Нийтлэг татварын бус орлого	00.00	27,000.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	00.00	27,000.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	00.00	27,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	163,678,300.00	187,572,800.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	163,678,300.00	187,572,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	163,678,300.00	187,572,800.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	171,833,231.69	196,339,835.96
21	УРСГАЛ ЗАРДАЛ	171,833,231.69	196,339,835.96
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	168,622,231.69	193,526,735.96
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	119,082,186.15	125,330,034.28
210101	Үндсэн цалин	119,082,186.15	125,330,034.28
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	15,209,604.19	15,666,254.29
210201	Тэтгэврийн даатгал	10,457,025.68	10,735,376.40
210202	Тэтгэмжийн даатгал	1,188,144.40	1,157,320.91
210203	ҮОМШӨ-ний даатгал	950,515.70	1,003,393.50
210204	Ажилгүйдлийн даатгал	237,628.68	250,849.36
210205	Эрүүл мэндийн даатгал	2,376,289.74	2,519,314.12
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	5,124,178.40	5,550,278.76
210302	Түлш, халаалт	5,124,178.40	5,550,278.76
2104	Хангамж, бараа материалын зардал	6,567,137.00	7,393,668.00
210401	Бичиг хэрэг	1,370,850.00	1,602,850.00
210402	Тээвэр, шатахуун	3,425,988.00	3,963,768.00
210403	Шүүдэн, холбоо, интернэтийн төлбөр	976,829.00	945,670.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	793,470.00	881,380.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	311,900.00	3,188,900.00
210604	Урсгал засвар	311,900.00	3,188,900.00
2107	Томилолт, зочны зардал	9,579,000.00	12,641,500.00
210702	Дотоод албан томилолт	9,579,000.00	12,641,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	492,750.00	492,750.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	288,000.00	283,300.00
210803	Даатгалын үйлчилгээ	119,250.00	108,300.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	52,500.00	76,150.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	33,000.00	25,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	12,255,475.95	23,263,350.63
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	530,000.00	2,470,000.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	8,903,923.48	8,013,367.96
261090	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,821,552.47	12,779,982.67
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,211,000.00	2,813,100.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,211,000.00	2,813,100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,211,000.00	2,813,100.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-8,154,931.69	-8,740,035.96
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	450,000.00	00.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	450,000.00	00.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-450,000.00	00.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-8,604,931.69	-8,740,035.96

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	163,678,300.00	187,572,800.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛГИЙН ОРЛОГО	163,678,300.00	187,572,800.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	163,678,300.00	187,572,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	163,678,300.00	187,572,800.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	163,678,300.00	187,572,800.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	163,678,300.00	187,572,800.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	157,590,247.53	171,979,717.33
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	118,899,138.87	125,330,034.22
210101	Үндсэн цалин	79,670,624.06	84,386,352.87
210102	Нэмэгдэл	35,692,514.81	30,089,826.45
210103	Унаа хоолны хөнгөлөлт	3,536,000.00	6,104,000.00
210104	Урамшуулал	00.00	4,749,854.90
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	15,440,381.26	15,666,254.35
210201	Тэтгэврийн даатгал	10,660,159.12	10,653,052.85
210202	Тэтгэмжийн даатгал	1,194,855.52	1,253,300.29
210203	ҮОМШӨ-ний даатгал	955,724.46	1,002,640.30
210204	Ажилгүйдлийн даатгал	239,131.08	250,660.09
210205	Эрүүл мэндийн даатгал	2,390,511.08	2,506,600.82
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	5,124,178.40	5,550,278.76
210302	Түлш, халаалт	5,124,178.40	5,550,278.76
2104	Хангамж, бараа материалын зардал	5,785,179.00	7,735,720.00
210401	Бичиг хэрэг	1,347,020.00	1,520,530.00
210402	Тээвэр, шатахуун	2,784,000.00	4,165,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	971,659.00	945,670.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	682,500.00	1,104,520.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,676,600.00	1,673,180.00
210604	Урсгал засвар	1,676,600.00	1,673,180.00
2107	Томилолт, зочны зардал	9,579,000.00	12,641,500.00
210702	Дотоод албан томилолт	9,579,000.00	12,641,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	438,050.00	492,750.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	233,300.00	283,300.00
210803	Даатгалын үйлчилгээ	108,300.00	108,300.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	71,450.00	76,150.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	25,000.00	25,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	647,720.00	2,890,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	647,720.00	2,890,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	6,088,052.47	15,593,082.67
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,266,500.00	2,813,100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,266,500.00	2,813,100.00
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	2,821,552.47	12,779,982.67
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,821,552.47	12,779,982.67
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	00.00	00.00
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)	00.00	00.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	00.00	00.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	00.00	00.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	00.00	00.00
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	00.00	00.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нооц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2021 оны 1-р сарын 01-нээрх үлдэгдэл	00.00	00.00	38,226,445.03	00.00	38,226,445.03
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	00.00	00.00	38,226,445.03	00.00	38,226,445.03
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-8,604,931.69	00.00	-8,604,931.69
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	00.00	29,621,513.34	00.00	29,621,513.34
D01	2022 оны 1-р сарын 01-нээрх үлдэгдэл	00.00	00.00	29,621,513.34	00.00	29,621,513.34
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	00.00	00.00	29,621,513.34	00.00	29,621,513.34
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	00.00	00.00	00.00	00.00	00.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	00.00	00.00	00.00	00.00	00.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	00.00	00.00	00.00	00.00	00.00
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-8,740,035.96	00.00	-8,740,035.96
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	00.00	00.00	20,881,477.38	00.00	20,881,477.38

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Өмнөх оны		Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл				
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	163,678,300.00	160,856,747.53	187,572,800.00	174,792,817.33
21	УРСГАЛ ЗАРДАЛ	163,678,300.00	160,856,747.53	187,572,800.00	174,792,817.33
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	160,411,600.00	157,590,247.53	184,706,100.00	171,979,717.33
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшлал	119,206,800.00	118,899,138.87	133,772,100.00	125,330,034.22
210101	Үндсэн цалин	78,198,300.00	79,670,624.06	84,918,800.00	84,386,352.87
210102	Нэмэгдэл	37,384,500.00	35,692,514.81	43,144,300.00	30,089,826.45
210103	Уриа хоолны хангөлөлт	3,624,000.00	3,536,000.00	5,709,000.00	6,104,000.00
210104	Урамшуулал	00.00	00.00	00.00	4,749,854.90
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх ниймтгэл	16,092,900.00	15,440,381.26	18,029,100.00	15,666,254.35
210201	Тэтгэврийн даатгал	11,324,600.00	10,660,159.12	12,798,300.00	10,653,052.85
210202	Тэтгэмжийн даатгал	1,192,100.00	1,194,855.52	1,307,700.00	1,253,300.29
210203	ҮОМШӨ-ний даатгал	953,700.00	955,724.46	1,046,200.00	1,002,640.30
210204	Ажилгүйдлийн даатгал	238,400.00	239,131.08	261,500.00	250,660.09
210205	Эрүүл мэндийн даатгал	2,384,100.00	2,390,511.08	2,615,400.00	2,506,600.82
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	5,247,800.00	5,124,178.40	6,327,800.00	5,550,278.76
210302	Түлш, халварт	5,127,800.00	5,124,178.40	6,027,800.00	5,550,278.76
2104	Хангамж, бараа материалын зардал	6,015,600.00	5,785,179.00	7,986,500.00	7,735,720.00
210401	Бичиг хэрэг	1,462,000.00	1,347,020.00	1,532,900.00	1,520,530.00
210402	Тээвэр, шатахуун	2,784,000.00	2,784,000.00	4,184,000.00	4,165,000.00
210403	Шуудан, холбоо, интернетийн төлбөр	977,700.00	971,659.00	1,177,700.00	945,670.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	791,900.00	682,500.00	1,091,900.00	1,104,520.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,684,100.00	1,676,600.00	1,729,300.00	1,673,180.00
210604	Урсгал засвар	1,684,100.00	1,676,600.00	1,729,300.00	1,673,180.00
2107	Томилуулт, зочны зардал	11,056,100.00	9,579,000.00	13,007,300.00	12,641,500.00
210702	Дотоод албан томилуулт	11,056,100.00	9,579,000.00	13,007,300.00	12,641,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, ху	458,300.00	438,050.00	508,300.00	492,750.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	233,300.00	233,300.00	283,300.00	283,300.00
210803	Даатгалын үйлчилгээ	108,300.00	108,300.00	108,300.00	108,300.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	91,700.00	71,450.00	91,700.00	76,150.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	25,000.00	25,000.00	25,000.00	25,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	650,000.00	647,720.00	334,570.00	2,890,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хайх	650,000.00	647,720.00	3,345,700.00	2,890,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	3,266,700.00	3,266,500.00	2,866,700.00	2,813,100.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	3,266,700.00	3,266,500.00	2,866,700.00	2,813,100.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	3,266,700.00	3,266,500.00	2,866,700.00	2,813,100.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	163,678,300.00	163,678,300.00	187,572,800.00	174,792,817.33
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	163,678,300.00	163,678,300.00	187,572,800.00	174,792,817.33
132001	Орон нутгийн төсвөөс	163,678,300.00	163,678,300.00	187,572,800.00	174,792,817.33
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00	00.00	00.00
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00	00.00	00.00
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	01.00	01.00	01.00	01.00
610001	Төсвийн байгууллага	01.00	01.00	01.00	01.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	07.00	07.00	07.00	07.00
620001	Удирдах ажилтан	01.00	01.00	01.00	01.00
620002	Гүйцэтгэх ажилтан	06.00	06.00	06.00	06.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Төв аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1-д заасан “Төсвийн ерөнхийлөн захирагч бүр хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсвийн хөрөнгө, өр, төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт, шалгалт хийх, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангахад чиглэсэн...” үүргийг хэрэгжүүлдэг, Төв аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяа байгууллага юм.

Аймгийн Засаг даргаар ахлуулсан Дотоод аудитын хороог 2 удаа хуралдуулж, 2021 оны үйл ажиллагааны тайлан, “Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны 2022-2024 оны дунд хугацааны стратеги төлөвлөгөө”, 2022 оны санхүүгийн хяналт шалгалт, дотоод аудитын ажлын төлөвлөгөөг хэлэлцүүлэн батлуулж, хэрэгжилтийг төсвийн ерөнхийлөн захирагчид тайлагнан ажилласан байна.

Төв аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь 2022 оны байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг 3 зорилтын хүрээнд 79 хэрэгжүүлэх арга хэмжээтэй баталснаас хэрэгжилт 94.9%-тай дүтнэгдсэн байна.

Төв аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь 2022 онд байгууллагын дарга, санхүүгийн хяналт шалгалтын улсын ахлах байцаагч 1, санхүүгийн хяналт шалгалтын улсын ахлах байцаагч 1, санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагч 4, аудитор 1 гэсэн 7 орон тоотойгоор үйл ажиллагаагаа явуулсан байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Санхүүгийн хяналт шалгалт, дотоод аудитын алба нь 2022 оны ажлын төлөвлөгөөний дагуу 13 сумын 91 төсөвт байгууллага, аймгийн төвийн 19 төсөвт байгууллага, 4 ОНӨҮГ, Аймгийн Засаг даргын тусгай удирдамжаар 2 байгууллага, ИТХ-аас баталсан ажлын хэсгээр 1 иргэнд, иргэдээс ирсэн 5 өргөдлийн дагуу нийт 122 байгууллага иргэнд санхүүгийн хяналт шалгалтыг гүйцэтгэсэн байна.

Тус алба нь аймгийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн 2022 оны эхний хагас жилийн хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсвийн хөрөнгө, өр төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт шалгалт хийх, үнэлэлт дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангах чиг үүргийг хэрэгжүүлж шалгагдсан тухайн байгууллагын үйл ажиллагааг сайжруулахад дэмжлэг үзүүлэх үндсэн зорилгоо биелүүлэн ажилласан байна.

Санхүүгийн хяналт шалгалт, дотоод аудитад хамрагдсан байгууллагуудын дүнгээр 2,863,506.5 мянган төгрөгийн зөрчил илрүүлж, зөрчлийг арилгуулахаар 2,342,967.7 мянган төгрөгийн 67 албан шаардлага хүргүүлж, 520,538.8 мянган төгрөгийн 186 төлбөрийн акт тогтоосон нийт 383,111.7 мянган төгрөгийн акт барагдуулж, 137,427.1 мянган төгрөгийн дутуутай, өмнөх оны актын барагдаагүй үлдэгдлээс 118,747.6 мянган төгрөгийг, тайлант оны 383,111.7 мянган төгрөгийн актыг барагдуулж, актын барагдуулалт 73.6 хувьтай хэрэгжүүлж ажилсан байна.

Төв аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь төсвийн шууд захирагчийн хувьд дараах хуулийн хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль

- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2022 оны Төсвийн тухай хууль
- Төрийн хэмнэлтийн тухай хууль
- Төрийн хяналт шалгалтын тухай хууль

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд буюу хөдөлмөрийн тухай хуулийн шинэчилсэн өөрчлөлттэй холбоотой өөрчлөлтийг нэмж тусган мөрдөж байна.

Сангийн сайдын 2022 оны 02 дугаар сарын 14-ны өдрийн СХШХ/01 дүгээр нэгдсэн удирдамжаар “Төв аймгийн 2016-2021 онуудад хууль бус шийдвэрийн улмаас төрийн албанаас халагдсан ажилтнуудад төсвөөс олгосон нөхөн олговор, түүнийг холбогдох хуулийн дагуу буруутай этгээдээр нөхөн төлүүлсэн эсэх”, 2022 оны 10 дугаар сарын 03-ны өдрийн СХШХ/06 дугаар нэгдсэн удирдамжаар “Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 211 тогтоолоор айл өрх, албан байгууллага, аж ахуйн нэгжид цахилгаан, дулаан, уур усны үнийн хөнгөлөлт үзүүлсэнтэй холбоотой үйлчилгээ үзүүлсэн аж ахуйн нэгжийн хөнгөлөлт, чөлөөлөлт, үйлчилгээний төлбөрийг нэхэмжилсэн тооцоог шалгах” хяналт шалгалтуудыг гүйцэтгэж, Дотоод аудитын хороогоор хэлэлцүүлсэн дүнг Сангийн яаманд нэгтгүүлж ажилласан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж буй дотоод хяналтаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэхэд, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Төлөвлөлтийн үе шатанд дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзсэн.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Төв аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус алба нь байгууллагын даргын 2015 оны 12 дугаар сарын 03-ны А/06 дугаар тушаалаар батлагдсан нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг мөрдөж байгаа ба тус бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцэж байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Төв аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь 2022 оны санхүүгийн тайлангаа Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна. Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 8,740.0 мянган төгрөгөөр буюу 29.5 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	0.0	0.0	0.0
Урьдчилгаа	0.0	0.0	0.0
Авлага	0.0	0.0	0.0
Бараа материал	3,705.6	2,979.0	-726.6
Үндсэн хөрөнгө	25,915.9	17,902.5	-8,013.4
Нийт хөрөнгө	29,621.5	20,881.5	-8,740.0
Өр төлбөр	0.0	0.0	0.0
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	29,621.5	20,881.5	-8,740.0
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	29,621.5	20,881.5	-8,740.0

Дээрх хүснэгтээс харахад, бараа материалын үлдэгдэл 726.7 мянган төгрөгөөр буурсан нь барилгын засварын материалын үлдэгдлээр өрөө тасалгааг засварласан нь нөлөөлсөн байна.

Үндсэн хөрөнгийн дансны үлдэгдэл тайлант оны хөрөнгийн элэгдлийн зардлаас шалтгаалан 8,013.4 мянган төгрөгөөр буурсан байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 20,881.5 мянган төгрөг болж 8,740.0 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг орон нутгийн төсвөөс 225,902.3 мянган төгрөг, нийт зарлагыг 225,902.3 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлсэн байна.

Төв аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн төсвийн төслөөс 38,329.5 мянган төгрөгөөр бууруулан 2022 оны урсгал зардлын төсвийг 177,572.8 мянган төгрөгөөр баталж ирүүлсэн байна.

Тус алба нь аймгийн Санхүү төрийн сангийн хэлтэст 2022 оны 11 дүгээр сарын 02-ны 33/59 тоотой 4,030.0 мянган төгрөгөөр, 2022 оны 12 дугаар сарын 12-ны 33/71 тоотой 3,300.0 мянган төгрөгөөр тус тус зардал хооронд шилжүүлэн зарцуулах хүсэлт хүргүүлж, өр авлагагүй гарахаар зохицуулалт хийлгэсэн бөгөөд аймгийн ИТХ-ын 2022 оны 6 дугаар сарын 24-ний 03 тоот тогтоолоор 10,000.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлэн 187,572.8 мянган төгрөгөөр 1 удаа төсөвт тодотгол хийсэн байна.

Энэ нь 2022 оны төсвийн төслөөр хүргүүлсэн саналд дотоод аудитын цар хүрээг нэмэгдүүлэх чиглэлээр 3 орон тоог нэмэгдүүлэхээр төлөвлөж хүргүүлсэн боловч орон тоо батлагдаагүйтэй холбоотой төсвийг бууруулж баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант оны батлагдсан төсөв 177,572.8 мянган төгрөгийг 10,000.0 мянган төгрөгөөр нэмэгдүүлж 1 удаа тодотгосон байна. Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх нэг Санхүүгийн

хяналт, эрсдэлийн удирдлага хөтөлбөрийн 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр 187,572.8 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр батлагдсаны дагуу гүйцэтгэлээр санхүүжилтийг 100 хувь олгож, оны эцэст төсвийн зарцуулаагүй үлдэгдэл 12,779.7 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Тайлант хугацааны төсвийн нийт зардлын гүйцэтгэл 174,792.9 мянган төгрөг буюу 93.2 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлаас 12,726.3 мянган төгрөг, ажил олгогчоос олгох тэтгэмжийн зардлаас 53.6 мянган төгрөг, нийт 12,779.9 мянган төгрөгийг дутуу зарцуулсантай холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/

д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	70429- Санхүүгийн хяналт, эрсдэлийн удирдлага 80101- Үндсэн үйл ажиллагааны зардал	184,706.1	171,979.8	12,726.3	93.2
2	70429- Санхүүгийн хяналт, эрсдэлийн удирдлага 80802- Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал	2,866.7	2,813.1	53.6	98.1
	Дүн	187,572.8	174,792.9	12,779.9	93.2

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тус байгууллага нь нэмэлт санхүүжилт аваагүй байна.

3.5.5 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тус төсөл хэрэгжих хугацаанд нийт нэг хөтөлбөрийн хоёр арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Хүснэгт 3. Төсөл хөтөлбөрийн арга хэмжээний хүрэх үр дүн, биелэлт

/мянган төгрөгөөр/

№	Хөтөлбөр	Хэрэгжих хугацаа	Хүрэх үр дүн	Хэрэгжилтийн явц	Зарцуулах төсөв	Зарцуулсан
1	70429- Санхүүгийн хяналт, эрсдэлийн удирдлага	2022.01.01-2022.12.31	Санхүүгийн хяналт, эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлэх	Санхүүгийн хяналт, эрсдэлийн удирдлага хөтөлбөр 93.2 %	187,572.8	174,792.9

Төв аймгийн Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны санхүүгийн хяналт, эрсдэлийн удирдлага /70429/ хөтөлбөр 93.2 % буюу 6,8 %-иар дутуу хэрэгжсэн нь 2022 оны төсвийн төсөлд үйлчилгээний 3 орон тоог батлуулж цалинг олгохоор тооцсон боловч орон тоо батлагдаагүйтэй холбоотойгоор зардал татан төвлөрүүлсэн байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана." гэж заасны дагуу Төв аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Г.Баянжаргал гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Төв аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 23-ны өдрийн 33/04 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр Төв аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны 2022 оны батлагдсан төсвийн нийт зарлагыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл "Дунд" гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1,5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг Төв аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны 2022 оны батлагдсан төсвийн нийт зарлага 187,572.8 мянган төгрөгөөс 1,5 хувиар буюу 2,813.6 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 75 хувиар буюу 2,110.2 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор тус байгууллага авч хэрэгжүүлсэн ажлын тайланг 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай хамт илтгэх хуудсаар хавсаргаж ирүүлсэн. Тус байгууллагын 2022 онд шаардлагатай гэж төсөвлөсөн 225,902.3 мянган төгрөгийн төсвийг 17.0 хувиар бууруулан батлахдаа үйлчилгээний 3 орон тоог нэмж баталж цалинг олгохоор тооцсон боловч Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.6-д "байгууллагын бүтэц, чиг үүргийг оновчтой тодорхойлж, цалин хөдсийг орлого гүйцэтгэл, үр дүн, үр ашигтай нь уялдуулан олгох" гэж заасныг хэрэгжүүлэн холбогдох 12,779.9 мянган төгрөгийн бодит зардлыг зарцуулалгүй хэмнэж, орон нутгийн төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Төв аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны шилэн дансны хуулийн хэрэгжилтийг шалгахад Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 12 мөнгөн гүйлгээг болон өмч хөрөнгө, мөнгө зарцуулах 12 шийдвэрийг хугацаандаа байршуулсан байна.

4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллагад бусад хууль тогтоомжийн хүрээнд шийдвэрлэх алдаа, зөрчилтэй асуудал гараагүй байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Төв аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын албаны эхний хагас жилийн байдлаарх санхүүгийн тайланд завсрын аудит хийгдсэн. Завсрын аудитын явцад асуудлын бүртгэлээр 1 залруулга, 2 зөвлөмж өгөгдсөн ба биелэлтийг жилийн эцсийн санхүүгийн тайлангийн аудитаар дахин хянахад, 1 залруулгыг хийж, 1 зөвлөмж нь үр дүнтэй хэрэгжсэн тул аудитын тайланд тусгаагүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Тус байгууллага нь 2021 оны санхүүгийн тайлангийн 2 албан шаардлага өгөгдсөнийг 100% хэрэгжүүлэн, биелэлтийг 2022 оны 6 дугаар сарын 08-ны өдрийн 33/89 тоотой ирүүлсэн байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Акт					
Албан шаардлага	2	1,976.0	2	1,976.0	100
Зөвлөмж	0	0.0	0	0.0	0
Нийт дүн	2	1,976.0	2	1,976.0	100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Төв аймгийн Засаг даргын дэргэдэх Санхүүгийн хяналт, дотоод аудитын алба нь дараагийн аудитаар анхаарал татахуйц асуудал байхгүй.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 16,013.9 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс аудитын явцад 12,779.9 мянган төгрөгийн алдааг залруулж, 764.0 мянган төгрөгийн 1 зөрчилд төлбөрийн акт тогтоож, 2,470.0 мянган төгрөгийн 1 зөрчлийг дахин давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.

Үүнд: Төсвийн гүйцэтгэлийн тайланд татан төвлөрүүлсэн 12,779.9 мянган төгрөгөөр тохируулга хийгээгүй байсныг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т "Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна" гэсэн заалтын дагуу аудитын явцад залруулсан.

5.1 Төлбөрийн акт

Албан томилолтоор ажиллах үеийн хоолны нөхөх төлбөр, албан хаагчийн хоолны зардлын нөхөх төлбөрийг давхардуулан тооцож олгосон 764.0 мянган төгрөгийн зөрчил байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.3-д "Албан томилолтоор ажиллаж байгаа албан хаагчийн тээврийн хэрэгсэл, байр, хоолны зардлыг албан томилолтоор ажиллуулсан байгууллага төсөвлөж олгосон тохиолдолд энэ хуулийн 3.1-д заасан байгууллага, албан тушаалтнаар төлүүлэхийг хориглоно" гэсэн заалттай нийцэхгүйгээс гадна санхүүгийн тайлангийн "Эрх ба үүрэг", "үнэлгээ ба хуваарилалт" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2 дахь заалт болон МҮЕА-ын 2020 оны А/95 дугаар тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.3.5-д "бүртгэл, тооцоог зөрүүтэй тооцоолсноос үр дагавар үүссэн" бол төлбөрийн акт тогтоох гэсний дагуу шийдвэрлэв.

5.2 Зөвлөмж

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дарааллаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

1. ***Зориулалт бус зарцуулалттай холбоотой асуудал***

1.1. Илрүүлэлт:

Дотоод албан томилолтын зардлыг 2,470.0 мянган төгрөгөөр хэтрүүлэн хичээл үйлдвэрлэлийн зардлаас гүйлгэн зарцуулсан зөрчил байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах" гэсэн заалттай нийцэхгүйгээс гадна санхүүгийн тайлангийн "Эрх ба үүрэг", "нийцсэн бөгөөд зохистой байх" батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Өгсөн зөвлөмж:

Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 6 дугаар сарын 15-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

6. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА,ЗӨРЧЛИЙН НЭГТГЭЛ

6.1 Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

мянган төгрөгөөр

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуул- сан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс:				Зөвлөмж	
							залруулсан		залруулаагүй			
	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн
Төсвийн гүйцэтгэлийн тайланд төвлөрүүлсэн мөнгөн дүнгээр тохируулга хийгээгүй алдаатай тайлагнасан байна	1	12779.9			1	12779.9	1	12,779.9				
Дүн	1	12,779.9	0	0.0	1	12,779.9	1	12,779.9	0	0.0	0	0.0

6.2 Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэлтгэл

мянган төгрөгөөр

Алдааны товч утга	Нийт зөрчил		Үүнээс:									
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн
Дотоод албан томилогчдын зардлыг 2.470.0 мянган төгрөгөөр хэтрүүлэн хичээл үйлдвэрлэлийн зардлаас гүйлгэн зарцуулсан байна.	1	2,470.0					1	2,470.0				
Албан томилогчид ажиглах үеийн хоолны нөхөх төлбөр, албан хаагчийн хоолны зардлын нөхөх төлбөрийг давхардуулан тооцож олгосон.	1	764.0	1	764.0								
Дүн	2	3,234.0	1	764.0	0	0.0	1	2,470.0	0	0.0	0	0.0

6.3 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

мянган төгрөгөөр

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс:					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн	тоо	дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Дүн								
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Дүн								
Нийт дүн	0	0	0	0	0	0	0	0